

Манмин Мэдээ

Номер 20 2012 оны Гуравдугаар сарын 11

Гадаадын 95 гаруй орноос Манмин Төв Сүмд интернэтээр бүртгэгдсээр буй итгэгчид Колумбад буй олон зуун итгэгчдийнхээ төлөө салбар сүм нээхээр бэлтгэж байна.



Манай сүмийн вэб хуудас болох www.manmin.org хаягаар олон мянган хүмүүс орж бүртгүүлэн сүмийн гишүүдийн тоо улам өссөөр байгаа билээ.

Манмин Төв Сүмийн вэб сайт нь Солонгос, Англи, Хятад Хэл, (Орчин цагын, Уламжлалт) Япон, Франц, Испани болон Орос гэх мэт долоон орны хэл дээр албан ёсны үйл ажиллагаа явуулдаг ба энэ сайтад «Шинэ итгэгчдийн бүртгэл» гэсэн цэс байдаг юм. Үүгээр дамжуулан 2006 оны нэгдүгээр сараас өнөөг хүртэл АНУ, Канад, Бразил, Панам, Молдав, Румын Герман, Мьянмар, Сауди Араб, Оман, Турк, Кувейт, Ботсвана, Тунис болон Австрали зэрэг 95 гаруй орнуудаас бүртгэгдсэн байгааг харж болох юм.

Одоогоор Колумба улсад манай сүмийн салбар сүм байхгүй ч гэсэн интернэтээр бүртгүүлсэн олон зуун итгэгчдийнхээ төлөө Колумба улсын нийслэл Боготад сүмийнхээ салбарыг нээхээр бэлтгэл шатандаа явагдаж байна.

Сүмийн вэб хуудсан дахь «Шинэ итгэгчдийн бүртгэл» цэсийг нээх болсон шалтгаан нь уг вэб сайтаар болон GCN (Global Christian Network) телевизээр цацагдах нэвтрүүлэгүүд болон Доктор И Жей руг пасторын номууд болон Манмин Мэдээ сонин дээрх Доктор И Жей руг пасторын сургаалууд, мөн гэрчлэлүүдээс ивээл хүртсэн олон хүмүүс Манмины гишүүн болох гэсэн хүсэлтүүдээ ирүүлсээр

байсан учраас энэ цэсийг нээх болсон билээ. Интернэтээр бүртгэгдсэн Венесуелийн Хосе Леонардо пастор «нэгэн танилаасаа Доктор И Жей руг пасторын DVD сургаалийг бэлгээр авсан ба түүнийгээ итгэгчидтэйгээ хамт сонсож их ивээл авлаа.» хэмээн ихэд талархсан сэтгэлээ илэрхийлэв. Оросоос Алкуйн Бажеф итгэгч өгүүлэхдээ «Би интернэтээр долоо хоног болгон Доктор И Жей руг пасторын сургаал номлолуудыг сондог ба итгэлээ улам өсгөхийн тулд би Манмин Төв Сүмийн гишүүн болон бүртгүүлсэн билээ» хэмээн хэлсэн юм.

Мөн Кени улсын Франсис хэмээх нэгэн эмэгтэй, «Гэр бүлийн ТВ болон интернэтээр дамжуулан Манмины сайн мэдээ тараах үйл ажиллагаатай танилцан ивээл аваад итгэгчээр бүртгүүлсэн бөгөөд түүний дараахан Найроби манмин сүмд очих болсон» хэмээн хэлэв. Мөн үүнээс гадна гадаадын олон орноос Доктор И Жей руг пасторт илгээсэн өвчтөний төлөөх залбирал авах хүсэлтүүд болон захидлууд өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь Манмин Төв сүмийг сүм нь дэлхийн дахинаа хэр нэр хүндтэй гэдгийг илтгэж байгаагийн илрэл юм.

2012 онд ч гэсэн манай сүм нь Ариун Сүнсний тэсрэлт мэт хүч нөлөөн дотор агуу гайхамшигтай Бурханы хүч чадлаар дэлхий дахинаа сайн мэдээ тараах үйлс улам өргөжих болно гэдэгтэй итгэл төгс байна.

Түүнчлэн Манмин Төв Сүмийн төрөл

бүрийн цуглаанууд нь GCN (Global Christian Network) телевизээр-ээр шууд нэвтрүүлэгддэг ба энэхүү нэвтрүүлэгээр дамжуулан дэлхийн өнцөг булан бүрээс олон үзэгчид хамт оролцож байгаа билээ. Доктор И Жей руг пасторын сургаалууд нь Англи, Япон, Хятад, Франц, Испани,

Монгол, Тагалоог хэлүүдээр шууд орчуулга хийгддэгээс гадна төрөл бүрийн өвчнөөс эдгэрсэн хүчит үйлсүүдийг гэрчилсэн гэрчлэлүүд өндөр түвшний чадварлаг магтаал дууны тоглолтууд зэрэг янз бүрийн ивээлээр дүүрэн хөтөлбөрүүд дүүрэн байдаг.

Бурханы Эрх мэдэлт хүч чадал

«Хэвлийдээ зулбасан гэгдэх хүүхэд хэвийн эрүүл төрлөө»



Сана Хан итгэгч (Пакистан)

Эмчилгээ хариуцсан эмч түүнд, «Үнэхээр гайхалтай. Хэвлий дэх хүүхэдэд хэд хэдэн удаа эхо зураг авч шинжилгээ хийсэн боловч хариу нь муу гарч, зүрхний цохилт нь огт мэдрэгдэхгүй байв. Гэтэл яаж амьд хэвийн төрснийг ойлгохгүй байна.» хэмээн ихэд гайхаж байлаа.

Өнгөрсөн 2011 оны Арваннэгдүгээр сарын 6-нд тэр Сана Хан эгч дүү хэвлийн дэх хүүхдээ хөдлөхгүй байгааг мэдэрч тэрээр эмнэлэгт очин шинжилгээ хийлгэж эхо зураг авахуулжээ. Гэтэл шинжилгээний хариу нь муу гарч хэвлий дэх хүүхэд нь амьгүй болсон байна гэдгийг батлаж байсан ба удалгүй хагалгаанд орох хэрэгтэй хэмээн эмч нар зөвлөв. Гэвч энэ эгч дүү маань хагалгаанд орохоос татгалзаж Арваннэгдүгээр сарын 9-нд болох «Гил Тэ шиг пасторыг урьсан Пакистан Лахоре эдгэрлийн цуглаан» д оролцохоор болов. Гил Тэ шиг пастор нь Солонгос дахь Дейжеон Манмин Сүмийн хариуцагч пастор бөгөөд Манмин төв сүмийн тэргүүн пастор Доктор И Жей руг пасторын залбирал хийж өгсөн гар алчуураар (Үйлс 19:11-12) индэр дээрээс эдгэрлийн залбирал үйлдсэн юм. Энэ үед Сана Хан эгч дүү гараа хэвлийн дээрээ тавин чин сэтгэлээсээ залбирал хүлээн авав. Үүний үр дүнд бүх биеэр халуун оргиж, мөн сэрүүн татахыг мэдрэхийн сацуу хэвлий дэх хүүхэд нь хөдөлж байхыг мэдрэгдэв.

Дараа өдөр буюу Арваннэгдүгээр сарын 10-ны өдөр тэрээр дахин эмнэлэг очин эхо зураг авахуулсанд хүүхдийн зүрхний цохилт нь хэвийн байдалтай болсон ба Арваннэгдүгээр сарын 11-нд хэвийн эрүүл хүүхэд төрүүлсэн юм. Халлелүяа!

Одоо энэ эгч дүү маань Исаак ТВ (Пакистаны Христийн суваг)-р дамжуулан Доктор И Жей руг пасторын сургаалийг байнга үзэж байгаа билээ.

«Бурхан нэгэн удаа айлдсан. Хүч чадал бол Бурханых гэдгийг би хоёр удаа сонссон.» (Дуулал 62:11).

Эрхэм таныг Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулганы «Эдгэрэл ба ивээл» цуглаанд хүрэлцэн ирэхийг урьж байна.

Ивээл дүүрэн сургаал, сэтгэл хөдлөм магтаал дуу, төрөл бүрийн өвчнөөсөө эдгэрэх эрх мэдэлт хүчийг та эндээс л мэдрэх болно.

Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулганы байранд 3-р сарын 30, 31нд 12:30-с эхэлнэ. Манай хаяг: Сүхбаатар дүүрэг 12-р хороо хангайн 3-57 тоот

(100айл 9-р дэлгүүрээс хойш 150 метрт)

Харилцах утас: 351437, 91173712, 88703712, 91615337

«Загалмайн Үг» цувралаас -(18)

Есүсийн загалмайн дээр айлдсан эцсийн долоон үг (2)

«Есүс эхийгээ болон хайртай байсан шавиа ойр зогсохыг хараад, эхдээ -Эмэгтэй, энэ бол таны хүү гээд, өнөөх шавьдаа -Энэ бол чиний эх гэж айлдав. Тэр цагаас хойш тэр шавь нь Есүсийн эхийг гэртээ аваачив.» (Иохан 19:26-27).

Ихэнхи хүмүүс үхэх нь ойртох үед өөрийн амьдралаа эргэн харж гэр бүл болон ойр дотныхондоо гэрээслэл болгон захиас үг үлдээдэг. Үүний нэгэн адил хүн төрөлхтөнийг аврахаар ирсэн Есүс загалмайн дээр цовдлогдон амьсгал хураахын өмнө хэдэн үг айлдсан байдаг ба түүнийг нь «Загалмайн дээр айлдсан эцсийн долоон үгс» хэмээн нэрлэдэг билээ.

Бурханы Хүүгийн хувьд хүн төрөлхтөнийг аврах төлөвлөгөөг төгс гүйцэтгэсэн Есүсийн эцсийн долоон үгсээр дамжуулан Эзэний зүрх сэтгэлийг гүнээ ухаарснаараа Бурханы жинхэнэ үр хүүхэд болох билээ. Өнгөрсөн дугаараас үргэлжлүүлэн Есүсийн загалмайн дээр айлдсан сүүлчийн үгсийн 3 дахь үгийг авч үзцгээе.

1. «Эмэгтэй, энэ бол таны хүү!»

Иохан 19:26-д, «Есүс эхийгээ болон хайртай байсан шавиа ойр зогсохыг хараад, эхдээ Эмэгтэй, энэ бол таны хүү» хэмээдэг. Энд таны хүү гэж байгаа нь хажуудаа зогсож буй хайрт шавь болох Иоханыг хэлж байгаа бөгөөд Есүс онгон Мариад Иоханыг өөрийн төрсөн хүү мэт харж хандаж яваарай хэмээн захиж байгаа байдал юм.

Тэгвэл Есүс онгон Мариад хандан «Эмэгтэй энэ таны хүү» хэмээн айлдсан нь ямар учиртай вэ? Энд нэгэн зүйлийг онцолж зөвөөр ойлгох хэрэгтэй зүйл нь Есүс онгон Мариаг, «эмэгтэй» хэмээн дууддаг байсан тухай юм.

Библид Есүс онгон Мариаг «Эж» гэж дуудсан тэмдэглэл нэг ч байдаггүй билээ. Дээр дурьдсан «Эх» гэдэг үг нь Иохан номыг бичиж үлдээсэн Есүсийн шавь Иоханы хувьд тухайн үеийн байдлыг илэрхийлж үлдээсэн болохоос Есүсийн айлдсан үг биш юм.

Мөн Есүс усыг усан үзмийн дарс болгон хувиргадаг үйл явдал нь Иохан номын 2-р бүлэг дээр гардаг ба энд ч гэсэн Есүс онгон Мариаг «эмэгтэй» хэмээн дууддаг. Энэ нь онгон Мариа хэзээ ч Есүсийн эх болох боломжгүй учраас юм. Есүс нь Бурхантай уг гарлаар нэг (Филиппой 2:6) бөгөөд Гурвын холбооны Бурханы Нэг нь тул яаж онгон Мариа тэр Эрхэмийн «эх» нь болж чадах билээ.

Бурхан бол өнө эртнээс үүрд мөнхөд оршин байдаг ба Тэрээр Өөрийнхөө тухай айлдахдаа «Би бол Би байдаг» (Египетээс гарсан нь 3:14) хэмээн айлдсан байдаг ба хэн нэгэн Түүнийг төрүүлээгүй ба бий болгоогүй билээ. Тиймээс, Бурханы Хүү Есүс нь махан биет хүн, Өөрийн бүтээл болох онгон Мариаг «Эх» хэмээн дуудах боломжгүй юм.

Үүнээс гадна, онгон Мариа Есүсийн эх болж чадахгүй шалтгаан нь эгэл жирийн хүн эцэг эхийнхээ эр эм эсээр бүрдэн жирэмсэлж, төрдөг бол Бурханы Хүү Есүс нь Ариун Сүнсээр онгон Мариагийн биед бүрэлдсэн Эрхэм билээ.

Хэрэв хэн нэгэн эр эм 2-н эр эм эсийг бүрэлдүүлд өөр нэгэн эмэгтэйн хэвлийд суулгахад тэр эмэгтэй хүүхэд төрүүлэхэд тэр хүүхдийг өөрийнхөө хүүхэд гэнэ гэж үү? Эсвэл инкубаторт өссөн хүүхэд инкубаторыг «эж» гэж дуудахгүй биз дээ?



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

Үүний адил, Есүс онгон Мариагаас төрлөө гээд Есүс эх гэж дуудах боломжгүйг ойлгох хэрэгтэй билээ.

Тэгсэн ч гэсэн онгон Мариаг Есүсийн эх хэмээн өргөмжилж түүний дүр төрхийг дуурайлган хийж, хиймэл шүтээн шиг мөргөн шүтэн үйлчилдэг нь Гурвын холбооны Бурхан таалах хэрэг огтхон ч биш билээ. Египетээс гарсан номын 20:3-4, «Чи Надаас өөр бурхадтай байж болохгүй. Чи өөртөө зориулан шүтээн эсвэл дээр тэнгэр дэх, доор газар дахь, газрын доор усан доторх юмны ямар нэг дүрсийг бүү хий.» хэмээн айлдсанчлан Бурханаас өөр Түүний бүтээл болох ямар нэгэн зүйлийг хэлбэр дүрсийг дуурайлган хийхгүй байж, мөн түүндээ мөргөж үйлчлэх явдал огт байх ёсгүй юм.

Есүсийн дараагийн үг нь «Эмэгтэй энэ бол таны хүү» хэмээн айлдсан нь онгон Мариаг тайтгаруулахын тулд айлдсан билээ. Тэрээр хайрт Есүс нь маш аймшигтай өвдөлт, зовлонг эдлэн үхэж байгааг харж буй онгон Мариагын зүрх сэтгэл урагдах мэт зовж шаналан уйлж буй Мариаг сэтгэлдээ агуулан эцсийн мөч хүртэл тайтгаруулан цаашид Өөрийн шавь Иоханаа өөрийн хүү шигээ хандахыг хүсдэг билээ.

2. «Энэ бол чиний эх!»

Иохан 19:27-д, «өнөөх шавьдаа-Энэ бол чиний эх гэж айлдав. Тэр цагаас хойш тэр шавь нь Есүсийн эхийг гэртээ аваачив.» хэмээн айлдсан байдаг. Есүс онгон Мариаг тайтгаруулан Иоханд хандан, «Энэ бол чиний эх» хэмээн айлдсан бөгөөд тэр цаг мөчөөс хойш Иохан онгон Мариаг гэртээ аваачин өөрийн эх шигээ үйлчлэн амьдарсан нь үнэн билээ.

Мариа нь онгон байхдаа Есүсийг төрүүлсэнээс хойш тэрээр өөрийн нөхөр Иосефын хэд хэдэн хүүхдүүдийг төрүүлсэн байдаг. Гэсэн хэдий ч, Есүс Мариаг хүүхдүүдэд нь захиж үлдээлгүй Өөрийн шавь Иоханд захиж үлдээсэн билээ. Үүнээс бид ямар зүйлийг ухаарч ойлгох хэрэгтэй вэ?

Филиппой номын 3:20-д «Харин бидний иргэний харьяалал нь тэнгэрт байгаа бөгөөд тэндээс бид Аврагч Эзэн Есүс Христийг хүлээж байна.» хэмээн

айлдсанчлан аврал хүртсэн Бурханы хүүхдүүд нь тэнгэрийн орны харьяат хүмүүс бөгөөд Эзэнийг хүлээн зөвшөөрч, амийн номонд нэр нь бичигдсэн Бурханы хүүхдүүд нь Бурхан Аавыг хүндлэн үйлчилдэг сүнс зүгийн гэр бүл юм. Тэгвэл Бурхан бидний сүнс зүгийн Аав болдог учир нь юу вэ?

Бурхан бол бүх амь амьдралын эх үүсвэр учраас юм. Хэдийгээр бид махан биеэр эцэг эхээсээ энэ газар дээр төрсөн ч эцэг эхийн маань эр, эм эс Бурханаас өгөгдсөн зүйл бөгөөд ураг удмаараа дээшлэн тооцож үзэхэд хүн төрөлхтөний эхлэл болох анхны хүн Адамд хүрдэг бөгөөд түүний амь амьдралыг мөн л Бурханаас хайрласан билээ. Бурхан Өөрөө Адамын бие махбодийг бүтээж хамрын нүхээр нь амин амьсгалыг үлээн оруулсан байдаг ба бидний амь амьдралын уг үндэс нь Бурханаас гаралтай билээ.

Мөн эрэгтэй эмэгтэй хүн хоорондоо гэрлэж хүүхэд төрүүлэх ч гэсэн Бурхан зөвшөөрөхгүй бол шинэ амь бүрэлдэхгүй бөгөөд тэр бүрэлдсэн хүүхдэд ч гэсэн сүнс сэтгэл өгөх хүртэл эрх мэдэл нь Бурханд харьяалагдаж байдаг. Хэдийгээр өнөө үед шинжлэх ухаан технологи өндөр хөгжиж байгаа үед хүний эд эсийг хувиран хүн бий болгох яригдсаар байдаг ч хүний сүнс сэтгэлийг хэзээ ч бий болгож чадахгүй билээ. Хэдийгээр хүнийг бүтээлээ ч сүнс сэтгэлийг болгож чадахгүй учир мал амьтантай л адил болох учир жинхэнэ хүн гэх боломжгүй юм.

Ялангуяа хэвлий дэх хүүхдийнхээ хүйс, зан араншин, гадаад төрхийг эцэг эх нь өөрсдийн хүссэнээр төрүүлэх боломжгүй юм. Зөвхөн Бурхан л хүний амь амьдрал бүх зүйлийг удирдаж байдаг нь үнэн билээ.

Манмин төв сүмд үр хүүхэдтэй болж чадахгүй хосууд Бурханы хүч чадлаар үр хүүхэдтэй болцгоосон гэрчлэлүүд маш олон байгаа билээ. Гэр бүл болоод 3, 5, 7, ба тэр ч бүү хэл 10 жилийн турш үр хүүхэдтэй болохын тулд янз бүрийн арга хэрэглэж байсан гэлцдэг билээ. Энэ мэт хүний арга барилаар хүссэнээ биелүүлж чадахгүй ч гэсэн Бурханы гайхамшигт эрх мэдэлт хүчинд итгэн даатгавал үр хүүхэдтэй болох ерөөлийг авах боломжтой билээ.

Тиймд хүнд сүнс сэтгэлийг өгөгч нь Бурхан бөгөөд үхэл амьдралыг удирдан жолоодогч нь мөн л Бурхан юм. Ийм Бурхан бидний сүнс зүгийн Аав билээ. Хэрэв Бурханд итгэхгүй дэлхий хүсэл тачаалын дагуу амьдардаг мөртлөө Бурханыг «Ааваа» гэж дуудах боломжгүй билээ.

Иохан 8:44-д, «Та нар эцэг чинь болох диаволаас гаралтай. Та нар эцгийнхээ хүслийг хийхийг хүсдэг. Тэр чинь эхнээсээ алуурчин байсан бөгөөд үнэн дотор зогсдоггүй. Учир нь түүнд үнэн байдаггүй. Тэр худал хэлэхдээ, чухам өөрөөсөө хэлдэг. Учир нь тэр худалч бөгөөд худал хуурмагийн эцэг нь юм.» хэмээн айлдсан байдаг.

Тиймд энэ газар дээр хэдийгээр цусан төрлийн холбоотой гэр бүл, ах дүүс ч гэсэн тэдгээр хүмүүс Эзэнд итгэхгүй бол тэнгэрийн улсад мөнхөд хамт амьдрахгүй. Есүс энэ тухай Матай 12:50-д, «Тэнгэр дэх Эцэгийн минь хүслийг биелүүлэгч хэн боловч Миний эх, ах эгч дүүс мөн гэж айлдав.» хэмээн айлдсан байдаг ба жинхэнэ гэр бүл бол сүнс зүгийн гэр бүл болохыг олж мэдүүлж байна.

Бид махан биеийн гэр бүлийнхнээ хайрлаж үйлчлэхдээ Бурханы өмнө зохистой сүнслэг хайраар хайрлах ёстой билээ. Магадгүй Бурханыг хүсэл төлөвлөгөөг эсэргүүцдэг гэр бүлийнхэндээ нийцүүлэх нь жинхэнэ хайр биш гэдгийг ухаарах хэрэгтэй юм. Жишээ нь таны эцэг эх ба ах дүү тань «Сүмд явж болохгүй» гэх ямар нэгэн зохисгүй зүйлийг «хамт хийцгээе» гэхэд үгийг даган түүнчлэн үйлдвэл энэ нь хайрлах бус харин ч үхэл рүү түлхэж буй хэрэг билээ. Харин эцэг эх ах дүүгээ хайрлавал заавал үнэний дотор хайрлаж үйлчлэх ёстой юм.

Тиймд гэр бүлдээ хайртай бол юуны түрүүнд хамтдаа аврал хүртэж Тэнгэрийн орон руу явахын тулд сайн мэдээг дуулгах хэрэгтэй юм. Тэгж чадвал мөнхийн тэнгэрийн улсад ч хамтдаа амьдрах боломжтой жинхэнэ сүнс зүгийн гэр бүл болох юм.

Хайрт та бүхэн,

«Загалмайн дээр айлдсан эцсийн долоон үгс»-н 3 дахь үгэнд загалмайд цовдогдсон Есүсийг хараад гашуудаж буй Мариагын сэтгэлийг тайтгаруулж буй Есүсийн хайр шингэсэн байгаа билээ.

Мөн Эзэн доторх ах, эгч дүүс нар жинхэнэ сүнс зүгийн гэр бүл болохыг мэдүүлж байна. Ийм Эзэний зүрх сэтгэлийг ухаарч Бурханыг илүү хайрлаж, Эзэн дотор сүнслэг хайрыг хуваалцахыг Их Эзэн Есүс Христийн нэрээр хүсэн ерөөе!

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
<http://www.manmin.org/english>
e-mail: manminministry@hotmail.com

Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин

Сэтгэл сэргээсэн уянгат хөгжмийн аялгуунд тааруулан вальс эргэн бүжиж миний зүүн талын хиймэл хөл минь эрүүл сайхан хөл болон хувирч мөсөн дээрх уран гулгалт хийх мэт яруу сайхан бүжиглэж байлаа. Үүн шиг үнэхээр гайхалтай хүлээн авалтын үйл ажиллагааг би мөрөөдөж байлаа. Өнгөрөгч оны 2-р хагасын «2 удаагийн онцгой Даниел залбирлын цаг»-р дамжуулан тийм сэтгэл хөдлөл дүүрэн байлаа.

Зургаан долоо хоногын турш үргэлжилдэг онцгой залбирлын цуглааны сүүлийн өдөр урамшуулал гардуулах үйл ажиллагаагаанд Тэргүүн пастор Доктор И Жей руг пасторын тэргүүн шагналыг хүртэх итгэгчийн нэрийг сугалах сэтгэл хөдлөм агшин байлаа. Тэгтэл «1-р их тойрог 1-н 2-р хэсэг дунд сургуулийн 3-р бүлэгийн сурагч Юү Га ёон!» хэмээн миний охины нэрийг дуудсан юм. Миний охин маань ч баярлан уйлмагцаа индэр өөд алхаж, би ч баярлан охиноо даган хамт гарлаа. Бид тэргүүн шагналын хамт Тэргүүн пастор Доктор И Жей руг пастортай хамт гэр бүлийн зураг даруулах боломж олдсон юм. Хайрын Бурхан бидэн шиг ээж охин 2-н амьдралыг санаж, урам өгсөн сэтгэл хөдлөм үйл явдал байлаа.

Хиймэл шүтээнд үйлчилж төөрөлдөж явсан би цэцэг насандаа хөлөө тайруулсан юм.

Миний гэр бүлийнхэн үе удмаараа хий шүтээн шүтдэг байлаа. Элэнц эмээ минь бөө хүн байсан ба ээж минь ч бас бөөгийн шашныг идэвхитэй дагадаг байлаа. Үүний улмаас манай гэрт өвчин зовлон, шаналал тасардаггүй байлаа. Би бүр багасаа элдэв хэрүүл маргаан зөрчил дунд байж, ахлах сургуулийн 2-р ангиас эхлэн (11-р ангиасаа) сэтгэл зүйн гүн хямралд орон архинд донтох гэх зэрэг хэвийн амьдралаар амьдарч үзээгүй билээ. Тэр ч бүү хэл нэгэн бөөгийн ятгалгаар бөө болох гэж бөөгийн сүнс дуудах ёслолд хүртэл орж байсан ба тэр сүнс дуудах ёслолд орж байхдаа би гэнэт дургүйцэж больж байсан удаа бий билээ. Түүний дараахан би тэр бөөд зөвхөн тусалдаг байлаа.

Тэгж байтал 1986 оны нэгэн өдөр зүүн хөл минь бага багаар өвдөж эхэлсэн юм. Эмнэлэгт очиж үзүүлэхэд намайг эсийн бөөгнөрөлийн хавдар гэж оношилсон юм. Цаг хугацаа өнгөрөх тусам бага багаар өвдөгний яс томрохын хажуугаар маш их өвдөлттэй байсны эцэст нь би зүүн хөлөө тайруулав. 29 настай цэцэг шиг залуу сайхан үедээ би хиймэл хөлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүн болов.

Хоёр жилийн дараа би нэгэн танилаараа дамжуулан нэгэн залуутай танилцаж үерхэж эхэлсэн ба гэр бүлийнхэн маань биднийг маш хүчтэй эсэргүүцэж хориглож байсан ч гэсэн бид хоёр таван жилийн дараа гэрлэсэн юм. Тэгээд Га-ёоныг төрсөний дараа манай нөхөр архи ууж надад хатуу ширүүн ханддаг болов.

Амьд Бурхантай уулзан амьдрал минь аз жаргалтай болж..

1996 онд, би нөхрийнхөө байдлыг тэвчиж чадалгүй охин Га-ёоныгаа гэврэн Гуро дүүргийн Гарибонг хороонд байдаг төрсөн



«Үзэсгэлэнтэй тэнгэрийн улсад очоод Эзэнтэйгээ би бүжиглэх болно»

Пак Еун уг сүмд үйлчлэгч (1-2 хэсэг, 3-2 Эмэгтэйчүүдийн бүлэг)

гэртээ очсон юм. Тэгтэл нэгэн өдөр Га-ёоныгаа нуруундаа үүрээд гэрийнхээ гадаа зогсож байтал «Та Манмин Төв Сүмийн тухай сонссон уу?» хэмээн хэн нэгэн хүн над дээр хүрч ирэн асуув. Тэр хүн нь тухайн үед миний амьдарч байсан газрыг хариуцаж байсан Ким Мёон сүл пастор байв.

Сайн мэдээ сонсоод сүм дээр явж очиход Манмин сүмийн итгэгчид надтай маш еелдэг халуун дотноор угтаж авсан юм. Ялангуяа манай хэсгийн гишүүд ялангуяа надад бүх талаар тусалж байлаа. Гэртээ байх үед би өөрийгөө хэнд ч хэрэггүй бүтэлгүй нэгэн үргэлж өөдрөг бус уруу дорой сэтгэлтэй байсан бол сүмд очсоноор миний сэтгэл өөрчлөгдсөн юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хандах эргэн тойрны харьцаа ба ялангуяа нөхрөөсөө хараат бус байж сүмдээ явах нь үнэхээр их аз жаргал билээ.

Түүнчлэн, Доктор И Жей руг пасторын сургаалыг сонсох тусам тэнгэрийн орон руу тэмүүлэх тэмүүлэлээр бялхдаг байлаа. Ингээд сүмд явж байхад нөхрийгөө өрөвдөх сэтгэл төрж зүгээр хаяж чадаагүй юм. Тийнхүү би нөхөртөө сүмийн тухай хэлж сайн мэдээний тухай ярьж өгч, эцэст нь манай нөхөр 1998 оны хоёрдугаар сард сүмд бүртгүүлсэн юм.

Миний нөхөр нас барсаны дараа би төрөл бүрийн өвчнөөр өвдөв.

Ингээд миний гэр бүлд аз жаргал хүрч ирсэн мэт байсан ч богинохон хугацаанд

байсан юм. Нөхөр маань 2000 онд элэгний хорт хавдартай хэмээн оношлогдсон ба түүнээс хойш жилийн дараа нас барав. Үүний хамт сэтгэлийн хямрал дахин туйлдаа хүрэв. Уйтгар гуниг айдас түгшүүр дотор өдөр шөнийг өнгөрөөж байлаа. «Чи удахгүй үхэх болно. Чи үхэлд хүргэх өвчтэй болсон» гэх дуу хоолой сонсогдоод унтаж ч чадахгүй болов. Эмнэлэгт очин шинжилгээ хийлгэгээл хариу нь сэтгэл зүйн архаг ноцтой хямралд орсон ба гүн стресстэй хэмээн оношлов. Тэр үеэс би сэтгэл хямралын эм байнга хэрэглэдэг болов.

2004 оны 11-р сард би Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах төвд очин ерөнхий шинжилгээ хийлгэв. Энэ шинжилгээгээр дамжуулан би нууц үедээ байсан сүрьеэ болон цусын цагаан эсийн хомсдол зэрэг өөр янз бүрийн өвчтэй байснаа мэдсэн юм. Эдгээр нь Бурханд итгэхээс өмнө үйлдсэн хорон муу үйлсүүд, янз бүрийн махан биеийн үйлсүүдээс болсон гэдгийг ухаармагцаа би Бурханы өмнө гэмшиж, мөн индэр дээрээс залбирч өгөх эдгэрлийн залбирлыг авч, итгэлээрээ Доктор И Жей руг пастортай гар барьсаар ирсэн билээ. Тэгтэл, удалгүй миний бие маш сайжирч 2005 онд би дахин шинжилгээнд ороход миний бүгд хэвийн эрүүл болсон байв.

Бурханы Үг болон залбиралаар сэтгэл зүйн архаг хямралаасаа хүртэл эдгэрч

Миний бие минь сайжирсан ч сэтгэл зүйн архаг хямралаасаа олигтой эдгэрсэнгүй. Ялангуяа хэдэн үе дамжин гэр бүлээрээ хиймэл шүтээнийг айттар шүтэж байсан тул хэр барагын гэмшлээр Бурханы өмнө хураагдсан гэм нүглийн хатуу ханыг нураах боломжгүй байлаа. Би хиймэл шүтээн шүтэж байхдаа ч мэдээж Эзэнд итгэсний дараа ч сэтгэл санаа хямрахаараа их бухимдаж, хүчтэй уурладаг байсан ба гомдоллох, бусдыг дүгнэх, шүүх гэх мэт зүйлүүдээ эргэн санан бүгдийг чин сэтгэлээсээ гэмшин үнэн дотор амьдрах гэж хичээж байлаа.

Хүч чадал дорой гэртээ хэвтээд баймаар байсан ч Бурханы ажил юм уу төрөл бүрийн мөргөл залбирал бүрт оролцохыг хичээж байлаа. Хэдий хөл муутай ч гэсэн би сүм цэвэрлэх болон сүмийн хөшигнүүдийг угаах зэргээр үйлчилж Бурханы өмнө сайныг хураах гэж бүх чадлаар чармайн зүтгэдэг байв.

2010 онд Доктор И Жей руг пасторын Эхлэл бүлгийн тайлбар сургаалд гарах «Амийн Үр» хэмээх сургаалыг арван удаа сонсохыг уриалж түүнчлэн сонсвол та бүхэнд гайхамшигт ерөөл ирэх болно хэмээн айлдсан юм. Би түүний дагуу дуулгавартайгаар дагахаар шийдэж, анх удаа сонсоход миний дотор тайван болж, хоол ч сайн шингэдэг болов. Мөн анхилуун үнэрийг үнэртэх зэрэг гайхамшигтай мэдрэмжийг биеэр мэдэрсэн юм. Түүнээс хойш эм уухгүйгээр унтдаг болов. Уйтгар гуниг, бухимдал, унжгар сул дорой байдал болон өөдрөг бус бодол санаанууд бүгд миний толгойноос бүр мөсөн арилсан юм. Ингэж удаан хугацааны турш зовж байсан сэтгэлийн архаг хямрах өвчнөөсөө төгс эдгэрсэн юм. Халлелүяа!

Шилжилтийн насны охин маань Доктор И Жей руг пасторын хайраар өөрчилөгдсөнд илүү аз жаргалтай байна

Мөн түүнчлэн орхиж болшгүй нэг талархах зүйл бол гэвэл миний охин Га-ёон маш хөөрхөн өөрчлөгдсөн явдал юм. Дунд сургуульд орсноос (7-р ангид орсноос) хойш охин маань маш их уурлаж уцаарладаг болсон ба итгэлийн амьдрал нь ч тэгш биш байлаа. Тэгж байтал дунд сургуулийн 3-р ангид (9-р ангид) байхад нь Доктор И Жей руг пастор зүүдэнд нь инээмсэглэн үзэгдэж залбирч өгсөн зүүд зүүдэлсний дараанаас эхлэн өөрчлөгдөж эхэлсэн билээ. Мөн 7 хоног бүрийн Эзэний өдрийн үдээс хойш мөргөл дараа Доктор И Жей руг пасторын удирдан явуулдаг «Бага цуглаан»-р дамжуулан хурдацтайгаар өөрчлөгдсөн билээ. Га-ёоны хэлэхдээ «Доктор И Жей руг пасторын дулаахан хайр яг миний аав шиг надад санагдсан» гээд хөөрхөн инээдэг билээ.

Одоо бид 2 хоорондоо сүнс зүгийн зүйл ярилцан аз жаргалтай итгэлийн амьдралаар амьдарч байна. Бүх талархал ба алдрыг Бурхан Аавдаа өргөн барихын зэрэгцээ Эзэний хайраар биднийг тэтгэж буй Доктор И Жей руг пасторгаа талархсанаа илэрхийлье!

Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:

Г. Анхбаяр СМТ 976-91173712

976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Испани хэлтнүүдийн зүрх сэтгэлийг хөдөлгөсөн үнэхээр гайхамшигт сургаал миний амьдралыг өөрчилсөн юм.

Алдо Гидо-Спано ахлагч (Перу Манмин Сүм)



2004 оны 12-р сар Перугийн нийслэл Лима хотноо болсон Доктор И Жей руг пасторыг урьсан Перугийн нэгдсэн их цуглаанаар дамжуулан энэ газарт суулгасан ариун сайн мэдээний үр жимс болох Перу Манмин Сүм болон Енласе Христийн ТВ сувгын тусламжтайгаар арвин их үр жимс боловсорч байна.

Би Дипломат ажилтан байхдаа маш үрэлгэн байсан ба архи ууж ихэд зугаа цэнгэлийг хөөдөг байлаа. Би 1992 онд ажлаасаа чөлөөлөгдөж гурван жилийн дараа Эзэнийг өөрийн амьдралдаа хүлээн авсан боловч миний амьдралд мэдэгдэхүйц өөрчлөлт гарахгүй л байв.

Доктор И Жей руг пасторыг урьсан Перу нэгдсэн их цуглаанд оролцсоны дараа..

Тэгж байтал нэгэн өдөр миний амьдралд гайхамшигт өөрчлөлт ирэв. Өрнөдөөс ирсэн хүмүүстэй уулзан аман орчуулга хийж байхдаа санаандгүй тохиолдлоор Манмин төв сүмийн тэргүүн пастор Доктор И Жей руг пасторын тухай сонсох болсон юм. Тэдгээр хүмүүс Перуд ажлын албан томилолтоор ирсэн Манмин төв сүмийн ажилтан хүмүүс болохыг олж мэдэв.

2004 оны Арванхоёрдугаар сард Доктор «Доктор И Жей руг пасторыг урьсан Перу нэгдсэн их цуглаан» болсон бөгөөд би энэ цуглааны үйл ажиллагаанд оролцоод миний нүдийг нээсэн үнэхээр гайхамшигтай зүйлсийг олж харав. ДОХ, хорт хавдар зэрэг олон төрлийн өвчтэй хүмүүс эдгэрч, суумгай тэргэнцэртэй хүмүүс, таягтай олон хүмүүс эдгэрч таяг, тэргээ хаян алхаж гүйж байгаа маш олон хүмүүсийг би өөрийн нүдээр харсан билээ.

Ариун сайн мэдээний ачаар жинхэнэ итгэлийг олж авав.

Тэр цаг үеэс хойш би одоо Перуд ажиллаж буй И Жей ху пасторын (Перу Манмин сүмийн хариуцагч Латин Америкийн сайн мэдээ тунхаглагч)-н сургаалын аман

орчуулгыг хариуцан ажиллаж байгаа билээ. Тэр пасторын сургаал сүнс зүгийн гүн утгатай билээ. Өөрийнх нь айлдаж буй бүх сургаал нь Манмин төв сүмийн тэргүүн пастор Доктор И Жей руг пасторын заасан зүйл хэмээн тайлбарладаг билээ. Долоо хоног бүр гайхалтай сургаалыг сонсож би болон манай гэр бүлийнхэн маш их өөрчлөгдөж байгаа эхлэв.

‘Хүн төрөлхтөний боловсруулан хөгжүүлэлт’, ‘Итгэлийн хэмжээ’ ‘Ариун байдал’ ‘Есүс ба Есүс Христийн ялгаа’ ‘Өнө эртнээс далдлагдсан нууц’ зэрэг сургаалиудыг сонсож сүнс зүгийн итгэлээр тогтмол хурдацтай өссөөр байгаа билээ.

Үүний нэг тод илрэл нь сургаалийн дагуу үйлдэн хэрэгжүүлдэг болов. Өмнө нь би зөвхөн Бурханы сургаалыг сонсдог мэдлэг төдий итгэлтэй байснаа ойлгосон юм.

Ном болон нэвтрүүлгээр сайн мэдээ тараах үйлсэд оролцох боломж надад олдож...

Мөн би Доктор И Жей руг пасторын «Загалмайн Үг» болон «Итгэлийн Хэмжээ» хэмээх номуудыг Испани хэлнээ орчуулж эхэлсэн билээ. Хамгийн сэтгэл хөдлөм зүйл нь Латин Америкийн шилдэг Христийн ТВ суваг болох Енласе ТВ-ээр Доктор И Жей руг пасторын сургаалыг Испани хэлнээ орчуулан дуу оруулах боломж олдсон нь их ерөөл гэж бодож байна. Одоогийн байдлаар би 500 сургаалийг орчуулан дуу оруулаад байна.

Энэ ажил нь Ариун сайн мэдээ газрын хязгаар хүртэл тунхаглагдахад маш чухал хэрэгтэй ажил гэж би боддог юм.

Доктор И Жей руг пасторын сургаалиуд нь Латин Америк төдийгүй дэлхий даяар буй Испани хэлтнүүдэд түгээгдэж,

ялангуяа Америкийн уугуул иргэдийн дундаас хамгийн их хувийг эзэлдэг испани хэлтнүүдэд түгээгдэж байгаа билээ. Мөн Койком (Испани хэл дээрх Христийн сувгуудын нэгдэл)-р дамжуулан агаарын болон хиймэл дагуулын нэвтрүүлэг, муж, бүс нутаг, улс орнуудыг хамарсан радио номлолын нэвтрүүлэг цацагдаж байна.

Би Доктор И Жей руг пасторын сургаалуудыг орчуулж дуу оруулж эхэлсэнээс хойш гайхалтай ерөөлдүүдийг хүртсээр байгаа билээ. Юуны өмнө миний амьдрал хангалуун болж миний амьдралын зорилго ч их өөрчлөгдсөн юм.

Сургаал доторхи Бурханы хүслийг үнэн зөв дамжуулан Доктор И Жей руг пасторын хүмүүсийн төлөө гэсэн хайрын сэтгэлийг агуулахын тулд хичээж байна. Ийм сэтгэлээр хичээж байтал миний дуу хоолой ч даруу зөөлөн болж хэдийгээр би Солонгос хэл мэдэхгүй ч гэсэн Бурхан надад Доктор И Жей руг пасторын сэтгэлийг мэдрэхэд тусалдаг юм. Ингэснээрээ би Бурханы үгийг илүү гүнзгий ойлгох болж Түүний зүрх сэтгэл ба хүслийг сайн ухаарах болов.

Шинэ Иерусалим руу тэмүүлэн итгэмжит гэр бүл болох ерөөлийг хүртэн...

Саяхан Эквадор улсын нийслэл Кито хотод амьдардаг нэгэн итгэгч маань Перу Манмин Сүмд хүрэлцэн ирэв. Тэрээр сургаал сонсоод ивээл хүртэн өөрийн баярласнаа илэрхийлэхээр Перу улс руу хүртэл ирсэн байжээ. Тэр итгэгч өгүүлэхдээ «Ийм гайхалтай сургаалийг урьд нь огт сонсож үзээгүй юм байна. Энэ сургаалиар дамжуулан жинхэнэ итгэлийн үнэ цэнийг ойлголоо» хэмээн чин сэтгэлээсээ талархаж байлаа. Энэ мэт Бурханы үгийг үнэн зөвөөр нь сурч аз жаргалтай итгэлийн амьдралаар амьдрах нь үнэхээр ерөөлтэй зүйл юм.

Одоо би тэнгэрийн улсын шагналд тэмүүлэн юунаас ч илүү ариун байдлыг олон хамгийн үзэсгэлэнтэй тэнгэрийн орон Шинэ Иерусалимд орохыг хүсэн тэмүүлж байна. Мөн Доктор И Жей руг пасторын сургаалын испани хэлний орчуулга болон сүмийнхээ санхүүгийн албаны дарга болон төлөвлөгөөний хэлтэсийн ажлыг хариуцан ажилладаг билээ.

Манай эхнэр ч гэсэн сүмд үйлчилэгч бөгөөд мөн бүсийн удирдагчаар хичээнгүйлэн ажиллаж байгаа билээ.

Бурханы зүрх сэтгэл ба Эзэний хайрыг мэдүүлж өгч, Шинэ Иерусалим руу удирдаж буй Доктор И Жей руг пастортай уулзах ерөөлийг хайрласан Бурхан Аавдаа бүхий л алдар магтаал өргөж байна.



2004 оны 12-р сар Доктор И Жей руг пасторыг урьсан


Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
 www.manmintv.org